

Албадан хөдөлмөрийн тухай конвенц(1930)-ийн 2014 оны протокол

Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах суурь зарчим нь тухайн үед бодитой оршиж байсан албадан хөдөлмөрийн тодорхой хэлбэрүүдийг таслан зогсоох зорилгоор баталсан хоёр конвенцид тодорхой эрх, үүргийн хэлбэрээр тусгагдсан байдаг. Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц нь колоничлогчид эзэмшил газар нутагтаа албан журмаар заавал хийлгэх хөдөлмөр ашиглах явдлыг таслан зогсооход чиглэсэн юм. Харин тухайн үед шинээр тусгаар тогтносон болон бусад орнууд албадан хөдөлмөрийг шинэ зорилгоор, тухайлбал улс төрийн өөр үзэл бодолтнуудыг нухчин дарах, эдийн засгийн хөгжлийг хангах зэрэгт ашиглах болсны хариуд Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенцийг батлан гаргажээ.

Одоо 29 дүгээр конвенцид албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн тодорхойлолт (аливаа хүн өөрөө сайн дурын үндсэн дээр гүйцэтгэхийг санал болгоогүй байхад нь ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж хийж гүйцэтгүүлсэн бүх ажил буюу үйлчилгээ); энэхүү тодорхойлолтод хамаарахгүй тохиолдлууд (заавал хаах хугацаат цэргийн алба; иргэний ердийн үүрэг; шүүхээр ял шийтгэсэн; онцгой байдлын нөхцөлд; хамт олон, бүлгийн хэрэгцээний жижиг ажил, үйлчилгээ); албадан хөдөлмөр эрхлүүлсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэн тохирох шийтгэл ногдуулж, хэрэгжилтийг нь чанд сахиулдаг байх гэсэн зохицуулалт хүчинтэй хэвээр үлдсэн.

105 дугаар конвенцийн хувьд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг таслан зогсоох, түүнчлэн албадан хөдөлмөрийг улс төрийн албадлага буюу засан хүмүүжүүлэх арга хэрэгсэл, улс төрийн үзэл бодолтой байж, түүнийгээ илэрхийлсэн, эсвэл тухайн байгаа улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцооныхоо эсрэг үзэл баримталсны шийтгэл, эдийн засгийг хөгжүүлэхэд ажиллах хүч дайчлах, ашиглах арга, хөдөлмөрийн сахилгын арга хэрэгсэл, ажил хаялтад оролцсоны шийтгэл, арьс өнгө, нийгмийн байдал, яс үндэс, шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхах арга хэрэгсэл болгож ашиглахгүй байхыг шаарддаг.

Албадан хөдөлмөр ашиглах явдлыг таслан зогсоох, тэр дундаа албадан хөдөлмөрлүүлэхийг эрүүгийн ноцтой гэмт хэрэг гэж тооцох нь дангаараа албадан хөдөлмөрийг үр дүнтэй устгахад хангалтгүй байгаа нь аажимдаа харагдсан. Конвенц, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах шинжээчдийн хороо (КЗХХШХ) 29 дүгээр конвенцийн хэрэгжилтийн талаарх дүгнэлтдээ хүчин төгөлдөр буй гэрээ, конвенциудын хүрээнд хангалттай тусгагдаж чадаагүй албадан хөдөлмөрийн орчин үеийн хэлбэрүүд, тэр дундаа цагаач ажилчдыг албадан

хөдөлмөрт өртөхөд хүргэж буй хүн худалдаалах, мөлжлөгийн нөхцөлд ажиллуулах тохиолдлын тоо нэмэгдэж байгаад санаа зовж буйгаа удаа дараа илэрхийлэх болсон.

Тиймээс Албадан хөдөлмөрийн тухай протокол болон Албадан хөдөлмөрийн нэмэлт арга хэмжээний тухай 2014 оны 203 дугаар зөвлөмжийн дагуу үндэсний бодлогын зорилго нь албадан хөдөлмөрийг устгахад чиглэхдээ албадан хөдөлмөрийг хөдөлмөрийн зах зээлийн төдийгүй эрүүгийн эрх зүйн асуудал гэсэн хандлагаар авч үзэж, гэмт этгээдэд хариуцлага хүлээлгээд зогсохгүй, албадан хөдөлмөр ашиглахаас сэргийлэх, хохирогчийг хамгаалах, эрхээ сэргээлгэх боломжоор хангах шаардлага тавигддаг. Үүгээрээ эдгээр баримт бичиг нь хөдөлмөрийн зах зээлийн институциуд, тэр дундаа хөдөлмөрийн хяналтын байгууллагад чухал үүрэг ногдуулж, цагаач ажилчдыг тусгайлан хамгаалахыг шаарддаг бөгөөд албадан хөдөлмөрийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй хэрэгтэй холбож авч үзсэн юм.

Монгол Улсын нэгдэн орсон албадан хөдөлмөрийн талаарх конвенциудын хэрэгжилт

Монгол Улс 29 болон 105 дугаар конвенциудад 2005 онд нэгдэн орсон. КЗХХШХ-оос эдгээр конвенцийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт, зөвлөмжийг Засгийн газарт хандсан хүсэлтүүддээ тусган ирүүлж байсан бөгөөд хамгийн сүүлчийн дүгнэлт, зөвлөмжийг 2017 онд гаргасан байна.

29 дүгээр конвенцийн хувьд КЗХХШХ Хүн худалдаалахтай тэмцэх дэд зөвлөл байгуулсныг болон хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж байгааг тэмдэглэсэн. Мөн хороо нь Засгийн газрыг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнтэй тэмцэх чиглэлд үргэлжлүүлэн хүчин чармайлт гаргаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ талаар мэдээлж байхыг хүссэн. КЗХХШХ мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг батлан мөрдүүлснийг анхааралдаа авч, Засгийн газрыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод хамгаалалт, туслалцаа, тэр дундаа эрх зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авах, мөн эдгээр үйлчилгээнд хамрагдсан хохирогчдын тооны талаар мэдээлэхийг хүссэн.

КЗХХШХ-оос тавьсан бусад асуудал: зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн алба хаагчид уг албаа орхих эрх чөлөө; цэргийн албаны тухай хуулиар хугацаат цэргийн алба хаагчдаар хийж гүйцэтгүүлж буй ажил, үүрэг; хорих ангид хийгдэж буй хөдөлмөр, ялтнуудыг хувийн компанид ажиллуулах; хорихын зэрэгцээ нийтэд тустай ажил хийлгэх ял оноож буй асуудал.

* ОУХБ-аас Монгол Улс 2014 оны протоколд нэгдэн орох боломжийг гурван талаар хэлэлцэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү танилцуулгыг бэлтгэв. Уг танилцуулгыг Монголын хуульчдын холбоо(МХХ)-ноос хийсэн үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулсан юм. Энэ дашрамд МХХ-нд талархлаа илэрхийлэв. Олон Улсын Хөдөлмөрийн Товчоо нь ОУХБ-ын гэрээ, конвенцийг тайлбарлах эрхгүй бөгөөд ОУХБ-ын эрх бүхий хяналтын байгууллагууд л үндэсний хууль тогтоомж, практик нь олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнд нийцэж буй эсэхийг тодорхойлж, дүгнэх эрхтэй гэсэн нийтлэг ойлголтын хүрээнд энэхүү танилцуулгыг бэлтгэсэн болохыг анхаарна уу.

105 дугаар конвенцийн хувьд КЗХХШХ нь Засгийн газар ажил хаялтад, тэр дундаа хууль бус ажил хаялтад оролцсоны төлөө албадан хөдөлмөр оролцуулсан ял шийтгэл ногдуулах эрх зүйн үндэслэл байхгүйг баталгаажуулсныг анхааралдаа авснаа тэмдэглэсэн. Хороо нь тус конвенцийн бусад асуудлын хэрэгжилтийг авч үзэхэд зайлшгүй шаардлагатай хууль тогтоомж, тэр дундаа хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, улс төрийн нам, эвсэл, жагсаал, цуглаан хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан хуулиудын хувийг илгээхийг Засгийн газраас дахин хүссэн.

Монгол Улсын хууль тогтоомж, практикт Албадан хөдөлмөрийн тухай протоколын хэрэгжилт, цаашид оруулж болох өөрчлөлтийн талаарх санал

Тодорхойлолт

1 дүгээр зүйл (3) дахь хэсэг – Конвенцид заасан албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн тодорхойлолтыг энд дахин баталгаажуулж, улмаар энэхүү протоколд дурдсан "арга хэмжээ"-нд албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор хүн худалдаалахын эсрэг тусгайлан авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг багтаана.

29 дүгээр конвенцид албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг тодорхойлсон боловч үндэсний хуульд ийм тодорхойлолт оруулахыг шаардаагүй. Тиймээс тус конвенц Монгол Улсад хүчин төгөлдөр болж үйлчлэхээс өмнө батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль(1999)-ийн 3.1.14-т заасан маш учир дутагдалтай тодорхойлолтын талаар КЗХХШХ шүүмж хэлээгүй. Үүнд:

“Албадан хөдөлмөр” гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг

хэлэхээр зааснаараа албадан хөдөлмөрийн ойлголтыг 105 дугаар конвенцид хориглосон таван хэлбэрийн 4-өөр нь хязгаарлаж (үүгээрээ 5 дахь хэлбэр буюу эдийн засгийн хөгжлийг хангах зорилгоор албадан хөдөлмөр ашиглахыг шууд бусаар зөвшөөрсөн), дээр нь аюултай ажлыг хамааруулсан байна.

Мөн Эрүүгийн хууль(2015)-ийн 13.13-т доорх байдлаар зааж, цалин хөлсгүй гэдгийг албадан хөдөлмөрлүүлсэн гэмт хэргийг тодорхойлох нэг элемент болгосон нь конвенцийн 25 дугаар зүйл, протоколын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу эрүүгийн хэрэг гэж үзэж, ял шийтгэвэл зохих хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хүрээг хэт явцууруулсан байна:

Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн

Түүнчлэн уг хуулийн 13.1-т заасан “хүн худалдаалах” гэсэн тодорхойлолтыг НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай (2000) протоколоос авч оруулсан байна. Уг тодорхойлолтод “албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор” гэж багтсан тул энэ нь албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор хүн худалдаалахын эсрэг тусгайлан арга хэмжээ авахыг шаардсан Албадан хөдөлмөрийн тухай протоколын заалттай нийцэж байна:

“Хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, орогнуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Мөлжих гэдэгт наад зах нь бусдыг биеийг нь үнэлүүлэх буюу бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх буюу үйлчлүүлэх, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах зэргийг ойлгоно.

- Одоо хөдөлмөрийн хуулийн шинэчлэл хийгдэж буй завшааныг ашиглан албадан хөдөлмөрийн тодорхойлолтыг 29 дүгээр конвенц болон түүний протоколд нийцүүлэх арга хэмжээ авбал зохино. Мөн Эрүүгийн хуулийн 13.13 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах, ялангуяа цалин хөлсгүй гэснийг хасах асуудлыг авч үзэх нь зүйтэй.

Үр дүнтэй арга хэмжээ, үндэсний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө

1 дүгээр зүйл (1) дэх хэсэг – Конвенцийн дагуу хүлээсэн албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг таслан зогсоох үүргээ биелүүлэх хүрээнд гишүүн улс бүр албадан хөдөлмөр ашиглахаас урьдчилан сэргийлэх, ийнхүү ашиглах явдлыг устгах, хохирогчийг хамгаалах, нөхөн төлбөр авах зэргээр эрхээ сэргээлгэх зохистой, үр дүнтэй арга хэрэгслээр хангах, албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхлүүлсэн гэм буруутай этгээдийг цээрлүүлэх үр дүнтэй арга хэмжээ авна.

1 дүгээр зүйл (2) дахь хэсэг – Гишүүн улс бүр ажилчдын болон ажил олгогчдын байгууллагуудтай зөвлөлдөн албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг үр дүнтэй, тууштай таслан зогсооход чиглэсэн үндэсний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, үүндээ эрх бүхий байгууллагуудаас системтэйгээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг шаардлагатай бол ажилчдын болон ажил олгогчдын байгууллагууд, түүнчлэн бусад сонирхогч бүлгүүдтэй харилцан уялдаатай зохион байгуулахаар тусгана.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль(2012)-ийн дагуу, Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах чиг үүрэг бүхий дэд зөвлөлийг 2013 онд Хууль

зүйн яамны дэргэд байгуулсан байна. 2017 онд Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталж, хүн худалдаалах гэмт хэргийн тодорхой хэлбэрүүд, тэд дундаа бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнчлэн хохирогчийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгасан байна

Хүн худалдаалсантай холбоотой тодорхой тооны хэргүүдийг шүүхээр шийдвэрлэсэн гэдгээс гадна үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл бага байгаагаас хүн худалдаалах элементийг нь оролцуулахгүй бол албадан хөдөлмөрийн нөхцөл байдалд хөтөлбөр хэр нөлөө үзүүлж байгааг үнэлэхэд хүндрэлтэй юм. Хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд ажил олгогчдын болон ажилчдын байгууллагууд оролцсон тухай мэдээлэл алга байна.

- Хүн худалдаалахыг оролцуулахгүйгээр албадан хөдөлмөрийг тодорхой тусгах үндэсний бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон нийгмийн түншүүдийг идэвхтэй татан оролцуулах арга хэмжээг авч үзэх нь зүйтэй.

Урьдчилан сэргийлэх

2 дугаар зүйл– Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээнд дараах арга хэмжээг багтаана:

(а) албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн хохирогч болохоос сэргийлэх зорилгоор хүмүүс, ялангуяа хохирогч болох эрсдэлтэй эмзэг бүлгийн хүмүүсийг сургах, мэдээлэл өгөх;

(b) албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн асуудалд холбогдохоос сэргийлэх зорилгоор ажил олгогчдыг сургах, мэдээлэл өгөх;

(c) дараах нөхцлийг бүрдүүлэх чиглэлд хүчин чармайлт гаргах:

(i) албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомж, шаардлагатай бол хөдөлмөрийн хууль нийт ажилчид болон эдийн засгийн бүх салбарт хамаарч үйлчлэх;

(ii) энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй хөдөлмөрийн хяналт, бусад албыг бэхжүүлэх;

(d) хүмүүсийг, ялангуяа цагаач ажилчдыг ажилд зуучлах, авах явцад гарч болзошгүй зүй бус болон хууран мэхлэх явдлаас хамгаалах;

(e) албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрөөс сэргийлэх, эрсдэлтэй нөхцөлд хариу арга хэмжээ авахын тулд нийтийн алба болон хувийн хэвшлийн зүгээс магадлан шинжилгээ хийж, засаж залруулдаг байхыг дэмжих;

(f) албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн эрсдлийг нэмэгдүүлж байгаа суурь шалтгаан, хүчин зүйлийг арилгах.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль(1997)-д олон нийтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ерөнхий мэдээлээр хангах асуудал тусгагдсан бол Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд илүү тодорхой буюу хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт явуулах асуудал тусгагдсан байна. Харин ажил олгогчдыг сургах, мэдээлэл өгөх тусгайлсан арга хэмжээ авдаг эсэх талаар мэдээлэл алга байна.

Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогод тусгагдаж байсны дагуу одоогийн шинэчлэн найруулж буй Хөдөлмөрийн тухай хуулийн төслөөр албан бус эдийн засагт хамарч үйлчлэх хүрээг илүү өргөтгөхийг зорьж байна. Харин Мэргэжлийн хяналтын ерөнхий газар(MXEG)-ын хөдөлмөрийн хяналтын байцаагч нар урьдчилан мэдэгдэж байж үзлэг, шалгалт хийх үүрэгтэй байдаг нь албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэхэд бодитой үүрэг гүйцэтгэхэд нь саад учруулж болзошгүй.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль(2001)-д ажилчдыг хамгаалах зарим зохицуулалт орсны дотор хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулах шаардлага багтсан байна.

- MXEG-ын хөдөлмөрийн хяналтын дүрэм, журамд өөрчлөлт оруулж байцаагч нар урьдчилан мэдэгдэлгүй ажлын байрны үзлэг, шалгалт хийх боломжийг олгох нь зүйтэй. 2001 оны хуулийг шинэчлэн найруулах үндсэн дээр боловсруулж буй Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн төсөлд цагаач ажилчдыг зуучлах, ажилд авах явцад албадан хөдөлмөрт өртөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн заалтуудыг нэмж тусгаж болох юм.

Хохирогчийг тогтоох, хамгаалах

3 дугаар зүйл – Гишүүн улс бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хохирогчийг олж тогтоох, чөлөөлөх, хамгаалах, эмчлэх, нөхөн сэргээх, түүнчлэн бусад хэлбэрээр тусалж, дэмжих үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Хүн худалдаалахтай тэмцэх хуулийн дагуу хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох үндсэн үүрэг Цагдаагийн ерөнхий газарт байгаа бөгөөд бүтэцдээ Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс байгуулсан байна. Харин тус хэлтсийн мөрдөн шалгасан ийм хэргийн тоо, шинж байдлын талаарх бүртгэл, мэдээлэл алга байна. Мөн хөдөлмөрийн хяналтын байцаагч нар албадан хөдөлмөрийн хохирогчийг олж тогтоосон тухай мэдээлэл алга байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн, материаллаг болон эмнэлгийн тусламж үзүүлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн арга хэмжээг хэд хэдэн хууль тогтоомж, тухайлбал, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль(2013)-д тусгасан байна. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу прокуророос эрүүгийн хэрэг үүсгэсний дараа хохирогч эдгээр тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжтой. Практикт хохирогчийг хамгаалахад чиглэсэн ихэнх үйлчилгээг ТББ-ууд үзүүлж байх шиг байна.

- Албадан хөдөлмөрийн хохирогчийг олж тогтоох, хамгаалахад хөдөлмөрийн хяналтын байцаагч нарын оруулах хувь нэмрийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч үзэх нь зүйтэй. Үүнд албадан хөдөлмөрийг таньж тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах ажлыг оруулж болох юм. Хохирогчийг хамгаалах арга хэмжээнд хамрагдах нөхцөл, болзлыг эргэн харж, хэрэг хянан шийдвэрлэх үйл явцаас хамааралгүйгээр нийт хохирогч хамрагдах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

Хохирогч эрхээ сэргээлгэх боломжоор хангагдах

4 дүгээр зүйлийн (1) дэх хэсэг – Гишүүн улс бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хохирогчийг улсынхаа нутаг дэвсгэрт байгаа эсэхээс болон эрх зүйн байдлаас нь үл хамааран нөхөн төлбөр авах зэргээр эрхээ сэргээлгэх зохистой, үр дүнтэй арга хэрэгслээр хангана.

4 дүгээр зүйлийн (2) дахь хэсэг – Гишүүн улс бүр эрх зүйн тогтолцооныхоо үндсэн зарчимд нийцүүлэн эрх бүхий байгууллагадаа бусдын эрхшээлд албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр эрхэлсний улмаас аргагүйн эрхэнд хууль бус ажиллагаанд оролцсон албадан хөдөлмөрийн хохирогчийг шүүн таслах буюу хариуцлага ногдуулахгүй байх эрхийг олгоход чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авна.

Олон улсын хамтын ажиллагаа

5 дугаар зүйл – Гишүүн улс бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх талаар харилцан хамтран ажиллана.

Монгол Улс иргэний болон эрүүгийн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх чиглэлд хэд хэдэн улстай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулсан ч албадан хөдөлмөр болон хүн худалдаалах асуудлаар хамтран ажиллах тухай тодорхой заалт оруулаагүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай 1997 оны 181 дүгээр конвенцийн хэрэгжилтийн анхны тайландаа Засгийн газар БНСУ (2004), Тайвань (2001), БНЧУ (1999), Япон (1998) улстай хоёр талт хэлэлцээр байгуулсан тухайгаа мэдээлсэн байна. КЗХХШХ-оос цагаач ажилчдыг ажилд зуучлах, авах, хөдөлмөр эрхлүүлэх явцад эрхийг нь зөрчих, хууран мэхлэх явдлаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан бүх хоёр талт хэлэлцээрийн талаарх мэдээллийг өгөх, мөн тэдгээр хэлэлцээрийн хувийг илгээхийг хүссэн байна.

Дүгнэлт

Албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг үр дүнтэй, тууштай таслан зогсооход чиглэсэн үндэсний бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, тэр дундаа албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор хүн худалдаалахын эсрэг авах тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх гэсэн Албадан хөдөлмөрийн тухай протоколын үндсэн шаардлагыг хангахуйц арга хэмжээнүүдийг Монгол Улс авсан байна. Гэхдээ хөдөлмөрийн удирдлагын эрх бүхий байгууллагууд, тэр дундаа хөдөлмөрийн хяналтыг 203 дугаар зөвлөмжид “хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах, албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн хохирогчдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлд ажилладаг бусад байгууллагуудтай хамтран ажиллахад шаардагдах эрх мэдэл, хөрөнгө нөөц, сургалтаар хангах” гэж заасны дагуу бэхжүүлж сайжруулах хэрэгцээ байгаа нь ажиглагдаж байна.

Тухайн зорилгодоо хүрэхийн тулд үндэсний бодлого боловсруулан хэрэгжүүлэхийг шаарддаг бусад конвенц, тухайлбал Монгол Улсын нэгдэн орсон 100, 111, 122, 182 дугаар конвенциудын нэгэн адил КЗХХШХ-оос протоколын практик хэрэгжилтийн талаар нэмэлт мэдээлэл хүсэж магадгүй юм. Энэ тохиолдолд шаардагдах мэдээллийг гаргах боломжтой гэж үзэж байна. Хэрэгжилтийг ийнхүү хянахын учир нь хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээгээ боловсруулах, хүрсэн үр дүнг нь үнэлэхэд зайлшгүй шаардлагатай мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийхэд оршдог юм.

Хүн худалдаалах гэмт хэрэг, албадан хөдөлмөрийн хохирогч нь гомдол нэхэмжлэлээ улсын прокурор, иргэний эсхүл эрүүгийн хэргийн шүүхэд гаргаж болох ба эрүүгийн болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагаагаар дамжуулан нөхөн төлбөр нэхэмжлэн авах боломжтой. Гэвч энэ нь зөвхөн албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор хүн худалдаалсан гэмт хэргийн хохирогчид хамааралтай юм. Практикт хохирогчид өөр нөхөн төлбөр шаардалгүйгээр зөвхөн аваагүй цалин хөлсөө л нэхэмжилдэг хандлага байна. Хууль бусаар оршин суугаа хохирогчийн эрхийг сэргээх тухайд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар түүнийг тус улсад зорчих, оршин суух, цагаачлах журам зөрчсөн гэсэн үндэслэлээр албадан гаргах арга хэмжээ авахаас хамгаалсан байна. Албадан хөдөлмөрт өртсөний улмаас хууль бус үйлдэл хийсэн хохирогчид хариуцлага тооцдоггүй практик байгаа эсэх талаар ямар нэгэн нотолгоо алга байна.

- Эрх зүйн байдлаас нь үл хамааран албадан хөдөлмөрийн бүх хохирогчдыг эрхээ сэргээлгэх боломжоор хангахын тулд холбогдох хууль тогтоомжийн судлан уялдуулах арга хэмжээ авах нь зүйтэй.



Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний нийцэл, тайлагналтын үндэсний чадавхийг бэхжүүлэх замаар GSP-Plus статусыг тогтвортой хадгалах төсөл(GSP+3)-ийн II үе шат